

## Засгийн Газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

### УЛСЫН ХИЛЭЭР ТӨРИЙН ХЯНАЛТЫН ДОР НЭВТРҮҮЛЭХ БАРААНД ЭКСПОРТ, ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. "Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Улсын Их хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Монгол Улсын олон улсын гэрээнд улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэхээр нэр төрлийг нь заасан бараанд экспорт, импортын лиценз /цаашид "лиценз" гэх/ олгоход энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Улсын хилээр нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лицензийг төрийн захиргааны эрх бүхий байгууллага /цаашид "лиценз олгогч" гэх/ олгоно.
- 1.3. Лиценз олгох үйл ажиллагааг үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, нэг цэгийн үйлчилгээний зарчмыг баримтлах хэлбэрээр зохион байгуулна.
- 1.4. Лиценз олгогч лиценз олгох эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсгийн баталгааг Улсын гаалийн ерөнхий газарт хүргүүлнэ.

#### Хоёр. Лиценз авах өргөдөл гаргах, хянан шийдвэрлэх журам

- 2.1. Барааг экспортлох, импортлох лиценз хүссэн өргөдлийг лиценз хүсэгч энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан "MNS 5022:2001" стандартын "Е" маягтаар гаргана. Өргөдөлд дурдсан мэдээллийн үнэн зөвийн хариуцлагыг өргөдөл гаргагч хүлээнэ.
- 2.2. Лиценз олгох өргөдөлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:  
өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол нотариатаар батлуулсан улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;  
өргөдөл гаргагч нь иргэн бол нотариатаар батлуулсан иргэний үнэмлэхийн хуулбар;  
тухайн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэхээр заасан бол нотариатаар баталсан тусгай зөвшөөрлийн хуулбар.
- 2.3. Лиценз хүсэгч өөрөө бүрдүүлэхээр хуульд тусгайлан зааснаас бусад шаардлагатай тодорхойлолт, дүгнэлтийг барааны онцлогоос шалтгаалан лиценз олгогч холбогдох байгууллагаас гаргуулна.
- 2.4. Лиценз олгогч өргөдөл болон хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 2.5. Лиценз олгогч шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар шалгуулах, магадлан шинжилгээ хийлгүүлэх эрхтэй. Энэ тохиолдолд лиценз хүссэн өргөдлийг шийдвэрлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.
- 2.6 Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол лицензийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан "MNS 5022:2001" стандартын "D" маягтаар олгоно.
- 2.7 Лицензийг 1 жил хүртэл хугацаагаар олгоно. Лицензийг нэг эх хувь, хоёр хуулбар /дубликат/ хувь үйлдэнэ. Лицензид нэр заасан барааны хадгалах, борлуулах хугацааны шаардлага болон тээвэрлэлт, хамгаалалт, чанар, стандартын нөхцөлийг хангасан байх үүргийг лиценз эзэмшигч өөрөө хариуцна.
- 2.8 Лицензийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж болохгүй.  
Гурав. Лицензийн хугацааг сунгах, лицензид нэмэлт, өөрчлөлт оруулах, лицензийг хүчингүй болгох
- 3.1 Экспорт, импортын гэрээний үүрэг биелүүлэх хугацаа, шаардлагатай уялдуулан лицензийг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.  
Лиценз олгогч лиценз сунгах болон лицензид заасан барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, нэвтрүүлэх боомтын нэрийг өөрчлөх, тодотгох өргөдлийг 3 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Лиценз сунгах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах өргөдлийг лиценз хүчинтэй байх хугацаанд гаргана.
- 3.2 Лиценз олгогч дараахь тохиолдолд лицензийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгоно:  
энэ тухай лиценз эзэмшигч хүсэлт гаргасан;  
лиценз эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;  
лиценз эзэмшигч иргэн нас барсан, сураггүй алга болсон;  
лиценз авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;

олгосон лицензийг засварласан;

гаалийн бүрдүүлэлт хийхэд хуурамч мэдээлэл өгсөн.

3.3 Лиценз олгогч лицензийг хүчингүй болгосон тухайгаа шийдвэр гаргаснаас хойш 3 хоногийн дотор лиценз эзэмшигч болон гаалийн байгууллагад мэдэгдэнэ.

Дөрөв. Лицензийн тайлан, мэдээ гаргах журам

4.1 Лиценз олгогч олгосон лицензийн мэдээллийг энэхүү журмын 3, 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу Үйлдвэр, худалдааны яаманд улирал тутам хүргүүлнэ.

4.2 Үйлдвэр, худалдааны яам лиценз олгох талаар мөрдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, олгосон лицензийн тухай нэгдсэн мэдээллийг Дэлхийн худалдааны байгууллагад зохих журмын дагуу мэдээлж байна.

---oOo---

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх

бараанд экспорт, импортын лиценз

журмын 1 дүгээр хавсралт

/ MNS 5022:2001 стандартын "Е" хавсралт/

Худалдагч/Seller		Экспорт, импортын лиценз олгох өргөдөл Application form for export, import license						
		Гэрээний дугаар/ Contract <sup>1</sup>			Он,сар, өдөр, /Date			
Хүлээн авагч/Consignee		Худалдан авагч/ Buyer						
		Илгээх улс/Country of delivery			Гэрээт улс/Contracting country			
		Гарал үүсэл/Country of origin			Хүлээн авах улс/Country of destination			
Тээврийн төрөл/ Mode of transport		Төлбөрийн нөхцөл/ Terms of payment						
		Валютын нэр /Currency			Rate	Ханш/	Хэлцлийн төрөл/Type of trade	
Хилийн боомт/Port		Нэмэгдэл тайлбар/Supplementary details						
код	Барааны тодорхойлолт Code	Барааны Commodity specification	нэгж	Хэмжих Unit	Тоо хэмжээ Quantity	үнэ price	Нэгж Unit	Үнэ Total
Гаалийн мэдүүлгийн <sup>1</sup> /Number of customs declaration of goods received			Өмнө заасан лицензийн гүйцэтгэл/Use of previous license			Дүн/ Total		

Хавсаргасан баримт

Attached documents

Хянасан/Revised by:

.....яамны

.....газрын ажилтан Гарын үсэг/Signature

Өргөдөл гаргасан/Applied by

..... Танилцсан/Seen by:

Байгууллагын/иргэний нэр .....газрын дарга Гарын үсэг/Signature

Name of organization/person

..... Тусгай тэмдэглэл/Notes

Албан тушаалын нэр/Position

.....

..... Гарын үсэг/ Signature

Харилцах утас/Telephone

Он, сар, өдөр/ Date Он, сар, өдөр/ Date

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх

бараанд экспорт, импортын лиценз олгох

журмын 2 дугаар хавсралт

/ MNS 5022:2001 стандартын D хавсралт/

Лиценз / License

Худалдагч/Seller		ORIGINAL					
		Лицензийн дугаар/ License <sup>1</sup>			Хүчинтэй хугацаа/Valid until		
		Гэрээний дугаар/ Contract <sup>1</sup>			Он,сар, өдөр, /Date		
Хүлээн авагч/Consignee		Худалдан авагч/ Buyer					
		Илгээх улс/Country of delivery			Гэрээт улс/Contracting country		
		Гарал үүсэл/Country of origin			Хүлээн авах улс/Country of destination		
Тээврийн төрөл/ Mode of transport		Төлбөрийн нөхцөл/ Terms of payment					
		Валютын нэр /Currency		Rate	Ханш/	Хэлцлийн төрөл/Type of trade	
Хилийн боомт/Port		Нэмэгдэл тайлбар/Supplementary details					
код	Барааны	Барааны	Хэмжих	Тоо	Нэгж	Үнэ	
	Code	тодорхойлолт Commodity specification	нэгж Unit	хэмжээ Quantity	үнэ Unit price	Total	

Дүн/ Total

.....Он, сар, өдөр/ Date



(Тамга) Мэдээлэл гаргасан :

Байгууллагын нэр:.....

Албан тушаал .....

Овог нэр .....